Биндэгноров ХХК-ийн Ерөнхий захирлын
2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн
А/28 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭ

Гэрээг нэг талаас Биндэгноров ХХК-ийг төлөөлж ..... ажилтай ..... овогтой ..... (цаашид **Хангагч** гэх), нөгөө талаас ..... регистрийн дугаартай ..... байгууллагыг төлөөлж ……. ажилтай ..... овогтой ..... (цаашид **Хэрэглэгч** гэх) нар Монгол Улсын “Иргэний хууль”, “Эрчим хүчний тухай хууль”, “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”, “Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч - хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”, Монгол Улсын стандарт “Цахилгаанаар хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага”-ыг тус тус үндэслэн …… (дүүрэг, аймаг) …....-р (хороо, сум)-ын ..... (хороолол, баг)-ын ..... (байр, гудамж) ……. тоот үл хөдлөх хөрөнгө (объект)-ийг цахилгаан эрчим хүчээр хангах зорилгоор .....…..... оны …..... сарын ……..... –ээс .....……. жил (.....)-ийн хугацаатай дор дурдсан нөхцөлтэйгөөр харилцан тохиролцож байгуулав.
үсгээр

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээг үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчтэй байгуулж, гарын үсэг зурж баталгаажуулна. Тус үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч гэрээ баталгаажуулах боломжгүй тохиолдолд итгэмжлэлийн үндсэн дээр хамтран хариуцагчаар гарын үсэг зуруулж болно. Харин үл хөдлөх эд хөрөнгийг түрээслэгч, түр оршин суугчтай байгуулах тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгө эзэмшигчээр давхар гарын үсэг зуруулж баталгаажуулна.

1.2 Төлбөр тооцооны зөрчил, гэрээтэй холбоотой аливаа асуудлаар үл хөдлөх хөрөнгө эзэмшигч, өмчлөгч, хамтран хариуцагч, түрээслүүлэгч, түрээслэгч, түр оршин суугч нар нэгэн адил эрх, үүрэг хүлээнэ.

1.3 “Хангагч, хэрэглэгч хоорондын эзэмшлийн зааг”-ийг НЭГДҮГЭЭР хавсралтад, “Цахилгаан эрчим хүчний тооцоо, төлбөр хийх хугацаа”-г ХОЁРДУГААР хавсралтад, “Хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний захиалгын хуудас”-г ГУРАВДУГААР хавсралтад тус тус тусгах ба энэхүү хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг байна.

1.4 Гэрээг бичгээр болон цахим аль ч хэлбэрээр хийж, өөрчлөлт оруулж, сунгаж, цуцалж болно.

1.4.1 Гэрээг цаасаар хийсэн тохиолдолд хоёр хувь үйлдэх ба талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулна. Талуудын хадгалсан хувь тус бүр нь нэгэн адил хүчин төгөлдөр байна;

1.4.2 Гэрээг цахимаар хийсэн тохиолдолд гэрээний үндсэн болон хавсралтуудад заасан нөхцөлүүдийг хэрэглэгч зөвшөөрч, баталгаажуулан хангагч талд илгээснээр хүчин төгөлдөр болно.

1.5 Талууд энэхүү гэрээний үүргийг биелүүлэхтэй холбогдсон гэрээний нөхцөлд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын “Иргэний хууль”, “Эрчим хүчний тухай хууль”, “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”, “Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч-хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”, Монгол Улсын Стандарт “Цахилгаан хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага” болон бусад хууль, тогтоомжийн заалтуудыг баримтлан шийдвэрлэнэ.

ХОЁР. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Хэрэглэгч нь эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйл, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 5 дугаар зүйл, Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэмд тус тус зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй байна.

2.1 Хэрэглэгч нь дараах эрхтэй:

2.1.1 Хэрэглэгч “Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ”-г анх удаа байгуулж байгаа тохиолдолд цаасаар хийх, нэмэлт өөрчлөлт болон сунгалтыг цахимаар хийхийг сонгох;

2.1.2 Цахилгааны төлбөр төлөх хэлбэр болон хангагчийн харилцдаг банкнаас сонголт хийж гэрээнд тусгах;
2.1.3 Хангагчийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл лавлагаа, санал, хүсэлт, гомдлыг дуудлагын 75050507, 70110507 утсаар болон www.bindegnorov.mn веб сайт, bindegnorov.llc@gmail.com и-мэйл хаяг,“Биндэгноров ХХК/Bindegnorov LLC” фэйсбүүк пэйж хаягаар эсвэл биечлэн ирж авах, өгөх;
2.1.4 Хангагч талын ажилтны бичиг баримтыг үзэх, шалгах;
2.1.5 Хангагчийн ажилтны буруугаас илүү төлбөр төлсөн, төлөх нөхцөл байдалд орсон бол цахилгаан эрчим хүчний бичилтийн залруулга хийлгэх, дараа сарын төлбөрт шилжүүлэх;
2.1.6 3 сар болон түүнээс дээш хугацаанд төлөгдөөгүй төлбөрөө төлөхдөө төлбөрийн нийт дүнгийн 30 хувийг урьдчилан төлсөн тохиолдолд авлага хэсэгчлэн барагдуулах гэрээ байгуулах талаар хүсэлт гаргах;
2.1.7 Цахилгаан эрчим хүчээр түдгэлзүүлсэн зөрчлийг арилгасан бол ЦЭХ-ээр сэргээлгэх хүсэлтийг хангагч талд гаргах;
2.1.8 Стандартын шаардлага хангаагүй цахилгаан эрчим хүч нийлүүлсэн тохиолдолд энэхүү гэрээний 7.1-д заасны дагуу хангагчид мэдэгдэж хохирлоо нэхэмжлэх;
2.1.9 Цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх хүсэлтээ хангагчид тавих эрхтэй бөгөөд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хэрэглэгч хариуцна;
2.1.10 Өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжийн техник ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээ, шинэчлэлттэй холбоотой асуудлаар хангагчаас мэргэжлийн туслалцаа хүсэх, зөвлөгөө авах, төлбөрт үйлчилгээ хийлгэх.

2.2 Хэрэглэгч нь дараах үүрэгтэй:

2.2.1 Хэрэглэгч нь тухайн байр, орон сууц, хашаа, газрыг шинээр худалдан авсан, өвлөн авсан, бэлэглэлийн гэрээгээр авсан бол уг объектыг өмнө нь эзэмшиж байсан хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг өөрийн нэр дээр шилжүүлэн авах хүсэлтийг тухай бүрд нь хангагчид гаргах;
2.2.2 Гэрээний хугацаа дуусах, өөрчлөлт орох, цикл өөрчлөгдсөн тохиолдолд хангагчийн мэдэгдсэнээр хэрэглэгч биеэр ирэх эсвэл цахимаар хүсэлт илгээн гэрээнд өөрчлөлт оруулж баталгаажуулах. Хэрэглэгч гэрээний өөрчлөлтийг баталгаажуулаагүй нь гэрээг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй;
2.2.3 Хэрэглэгч өөрийн тухай мэдээлэл (утасны дугаар, и-мэйл хаяг, үйл ажиллагааны чиглэл гэх мэт) болон цахилгаан шугам, тоноглолын схем, горим, зориулалт, хүчин чадал, үзүүлэлтүүдийг хангагчид үнэн зөв өгөх, мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдол бүрт цаг тухайд нь мэдэгдэж байх;
2.2.4 Өөрийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний захиалгыг жил бүр үнэн, бодитойгоор хангагчид гаргаж өгөх;
2.2.5 Цахилгаан шугам, тоноглолын техник ашиглалт, аюулгүй ажиллагааг хангуулах талаар хангагчийн тавьсан шаардлагыг биелүүлэх;
2.2.6 Цахилгаан эрчим хүчээр хангагчийн төлөөлөгч болох эрх бүхий ажилтныг өөрийн эзэмшлийн дэд станц, шугам тоноглолд орох, ажил үйлчилгээ явуулахад саад учруулахгүй байх, дэд станцын хаалга, хашааны цоожны түлхүүрийг хоногийн 24 цагаар байнгын бэлэн байдалд байлган хангагчийн төлөөлөгчийг үйл ажиллагаагаа явуулах боломжоор хангах;
2.2.7 Гэрээнд тусгасан эзэмшлийн заагийн дагуу өөрийн эзэмшлийн цахилгааны шугам сүлжээ, барилга, орон сууцны доторх холболт, тэрчлэн цахилгаан хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, галын аюулаас урьдчилан сэргийлэх шаардлагыг бүрэн хариуцах, цахилгаан шугам сүлжээ, тоног төхөөрөмжид аюул осол гарч болзошгүй нөхцөл бүрдсэн тохиолдолд хангагчид нэн даруй мэдэгдэх;
2.2.8 Цахилгаан эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийг мөрдөх, өөрийн эзэмшлийн газарт байгаа цахилгаан шугам тоноглол, тэдгээрт очих замыг чөлөөтэй байлгах, кабель, агаарын шугамын хамгаалалтын зурваст газар шорооны болон бусад ажлыг хангагчийн зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэхгүй байх;
2.2.9 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан шугам, тоноглолд ААД, ТАД-ын дагуу тогтмол үзлэг хийх, засварын ажлыг жилд нэгээс доошгүй удаа хийх;
2.2.10 Хэрэглэгч нь нарийн мэдрэмжтэй тоног төхөөрөмж хэрэглэж байгаа бол гүйдэл, хүчдэлийн хэлбэлзлээс хамгаалах төхөөрөмж тавьсан байх;
2.2.11 Хэрэглэгч нь үйл ажиллагааны чиглэл, болон суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх тохиолдолд хангагчид мэдэгдэн техникийн нөхцөлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргах;
2.2.12 Хэрэглэгч нь сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг түгээх сүлжээнд холбох болон үүсгүүрээсээ түгээх сүлжээнд нийлүүлэх бол заавал техникийн нөхцөлийн дагуу холболтыг хийлгэж нэмэлт гэрээ байгуулсан байх;
2.2.13 Цахилгаан хангамж тасалдсан тохиолдолд хүний амь нас, улсын эрх ашиг, үйл ажиллагаанд нь ноцтой хохирол учирч болзошгүй онцлогтой болон халаалтаа цахилгаанаар бүрэн шийдсэн хэрэглэгч нь нэмэлт нөөц тэжээлийн эх үүсвэр (дизель, генератор) суурилуулсан байх;

2.2.14 Өөрийн эзэмшлийн дэд станц, шугам тоноглол нь, хоёр талын цахилгааны эх үүсвэрээс тэжээлтэй болон автомат сэлгэн залгагч төхөөрөмж суурилуулсан, мөн аваарийн нөөц тэжээлийн эх үүсвэр (дизель, генератор)-тэй болон эдгээрийг шинээр суурилуулах бол аюулгүй ажиллагааны үүднээс хангагчид заавал мэдэгдэж бүртгүүлэх;
2.2.15 Өөрийн эзэмшлийн шугам тоноглолоос хангагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдийг цахилгаан эрчим хүчинд холбохгүй байх, суурилагдсан хүчин чадал, хийц, зориулалтыг нь дур мэдэн өөрчлөх, өргөтгөхгүй байх;
2.2.16 Эрх бүхий байгууллагаар шалгагдаж битүүмжлэгдсэн тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагааг алдагдуулахгүй, зөөж шилжүүлэхгүй байх;
2.2.17 Цахилгаан эрчим хүчийг зүй зохистой ашиглаж, хэрэглэсэн цахилгаан эрчим хүчнийхээ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх;
2.2.18 Нөхөн тооцооны төлбөр, алданги, цахилгааны хэрэглээг түдгэлзүүлэх болон сэргээх, бусад үйлчилгээний төлбөр, шүүхэд шилжүүлэх мэдэгдэл хүргэсний хураамжуудыг зохих журмын дагуу төлөх;
2.2.19 Хэрэглэгч нь цахилгаан эрчим хүчний хэрэглээний захиалгыг жилээр тооцож бодит хэрэглээнээс ±2 хувиас илүүгүй зөрүүтэйгээр төлөвлөж хангагчид гаргаж өгөх; (Тухайн жилийн захиалгыг өгөөгүй тохиолдолд өмнөх оны захиалгыг үндэслэн тооцно)
2.2.20 Хэрэглэгч нь цахилгаан сүлжээнээс салгуулах тохиолдолд хүсэлтээ өргөдөл, эсвэл 7505-0507 дугаарын утсаар хангагчид заавал мэдэгдэж, захиалга өгөх. Хангагч нь хүсэлт болон өргөдлийг шийдвэрлэх шаардлагатай хугацааг хэрэглэгчид хэлэх бөгөөд, хэрэглэгч нь үйлчилгээний төлбөр, сүүлийн удаа авсан тоолуурын заалтаас хойш таслалт хийгдэх өдөр хүртэлх тоолуурын заалтын зөрүүгээр гарсан цахилгааны төлбөрийг урьдчилан төлөх;
2.2.21 Хэрэглэгч нь хангагчаас өгөх мэдэгдэл мессежийг авах боломжгүй удаан хугацаагаар эзэнгүй байх тохиолдолд хангагчид мэдэгдэж, цахилгааны төлбөрийг урьдчилан тооцоолж төлөх;
2.2.22 Хэрэв 6-35 кВ-ын дэд станц, шугам тоноглол эзэмшдэг бол эдгээр шугам тоноглолын ашиглалт, аюулгүй ажиллагааг хариуцсан мэргэжлийн ажилтныг томилон ажиллуулах эсвэл мэргэжлийн ажилтан, хуулийн этгээдтэй ашиглалт үйлчилгээний гэрээ байгуулсан байх;
2.2.23 Хэрэглэгч нь 6-35 кВ-ын өндөр хүчдэлийн шугам, тоноглол эзэмшдэг бол хангагчтай “ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ”-г байгуулах;
2.2.24 Хэрэглэгч нь техникийн нөхцөлд заагдсан суурилагдсан хүчин чадлыг хэтрүүлэхгүй байх.

ГУРАВ. ХАНГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Хангагч нь Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйл, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 9 дүгээр зүйл, Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэмд тус тус зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй байна.

3.1 Хангагч нь дараах эрхтэй:

3.1.1 Цахилгаан эрчим хүчний шугам, сүлжээний хамгаалалтын зурвас дотор хангагчийн зөвшөөрөлгүйгээр хашаа, байшин, барилга, гэр болон бусад объектыг байршуулсан хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр хангахгүй байх, гэрээ байгуулахаас татгалзах;
3.1.2 Хангагчийн горим ажиллагаа, цахилгаан эрчим хүчний чанарт сөрөг нөлөө үзүүлэх тоног төхөөрөмж ашиглахыг хориглох;
3.1.3 Хэрэглэгчийн тоног төхөөрөмжид ашиглалт болон аюулгүй ажиллагааны дүрмийн зөрчил илэрсэн тохиолдолд засвар үйлчилгээ хийх талаар шаардлага өгөх;
3.1.4 Хангагчийн шуурхай ажиллагааны эрх бүхий ажилтан нь ажлын шаардлагаар хоногийн 24 цагийн алинд ч хэрэглэгчийн эрчим хүчний тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийх, горим ажиллагааг хянах, тасралт саатлыг устгах болон ажлын байр бэлдэхтэй холбоотой сэлгэн залгалтыг хийх;
3.1.5 Хэрэглэгч нь хангагчийн эзэмшлийн цахилгаан шугам сүлжээ, тоног төхөөрөмжид учруулсан эвдрэл, гэмтлийг засах талаар шаардлагатай арга хэмжээ авахгүй бол хангагч засварыг хийж, гарсан зардлаа хэрэглэгчээс шаардан авах;
3.1.6 Хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж тасралт саатал, гэмтэл гарсан тохиолдолд дутуу түгээсэн цахилгаан эрчим хүчний үнэ болон бусад хохирлоо нэхэмжлэх;
3.1.7 Хувийн эзэмшлийн трансформатортай хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний тооцоон дээр сар бүр трансформаторын хоосон явалтын энергийн төлбөр тооцож авах;
3.1.8 Хангагч нь зайлшгүй шалтгааны улмаас хэрэглэгчийн бичилт хийх, төлбөр тооцоо хийх циклийн хугацааг өөрчлөх;
3.1.9 Хэрэглэгч өөрийн эзэмшлийн цахилгаан шугам тоноглолд хангагчийн тавьсан ашиглалтын шаардлагыг биелүүлээгүйгээс үүдэн хангагчийн эзэмшлийн шугам сүлжээнд тасралт саатал гаргах магадлалтай болсон бол сүлжээнээс тасалж тусгаарлах;
3.1.10 Цахилгаан эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг нөхөн тооцох, нөхөн тооцооны төлбөрийг нэхэмжлэх;

3.1.11 Авлага хэсэгчлэн барагдуулах гэрээний нөхцөл зөрчиж төлбөрөө төлөөгүй мөн 3 сар буюу 90 хоногоос дээш хугацаагаар төлбөрөө барагдуулаагүй бол хэрэглэгчийг шүүхэд шилжүүлэх;
3.1.12 ЭХЯ-ны Хяналт шалгалтын газар, Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэл, дүүргийн тамгын газар болон бусад удирдах дээд газруудаас ирүүлсэн шийдвэрийг үндэслэн хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлэх;
3.1.13 Авлагатай хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчээ сэргээлгэх захиалгыг хүлээн авахгүй байх;
3.1.14 Хангагчийн эрх бүхий ажилтан “Эрчим хүчний тухай хууль”-ийн 32.2 дугаар заалтыг үндэслэн хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх;
3.1.15 Энэхүү гэрээнд заасан үл хөдлөх хөрөнгө эзэмшигч, өмчлөгч нь цахилгаан эрчим хүчний хэрэглээний төлбөрийг 3 сар дараалан төлөөгүй бол хангагчтай байгуулсан гэрээ бүхий бусад үл хөдлөх хөрөнгийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хязгаарлах;
3.1.16 Хангагч нь хэрэглэгчийн ирүүлсэн цахилгаан эрчим хүчний захиалгыг үндэслэн эрчим хүчний “графикийн хазайлт” гаргасан тохиолдолд хазайлтын төлбөрийг сар бүр нэхэмжлэх.

3.2 Хангагч нь дараах үүрэгтэй:

3.2.1 Хэрэглэгчийг Монгол улсын стандартын шаардлагад нийцсэн цахилгаан эрчим хүчээр хангах;
3.2.2 Хангагчийн буруутай үйл ажиллагааны улмаас хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийг гэмтээсэн бол өөрийн хөрөнгөөр засварлаж өгөх; (7.1-д заасан хохирол тогтоосон актыг үндэслэнэ)
3.2.3 Ажилтны буруугаас хэрэглэгчийг илүү төлбөр төлүүлсэн, төлөх нөхцөл байдалд хүргэсэн бол алдааг залруулах, дараа сарын төлбөрт шилжүүлж тооцох;
3.2.4 Хэрэглэгчийн бичилт төлбөр тооцооны циклийн хугацааг өөрчилсөн бол энэ тухай төлбөр тооцоо хийх хугацаа болохоос 14 хоногийн өмнө хэрэглэгчид мэдэгдэх;
3.2.5 Хэрэглэгч зөрчлөө арилгаж үйлчилгээний төлбөр болон хураамжуудаа төлсөн тохиолдолд хангагч тал хэрэглэгчийн цахилгаан хангамжийг холбогдох журам стандартад заасан хугацаанд сэргээх;
3.2.6 Эрчим хүчний төлөвлөгөөт таслалтын талаар хэрэглэгчид 24-өөс доошгүй цагийн өмнө урьдчилан мэдэгдэх;
3.2.7 Хэрэглэгчийн тухай мэдээллийн нууцыг чандлан хадгалах;
3.2.8 Хангагч нь төлбөрийн нэхэмжлэлийг гэрээнд заасан хугацаанд харилцагч банканд хүргэсэн байна.
3.2.9 Хэрэглэгчийн шугам тоноглолд гэрээ, хэлцлийн дагуу засвар үйлчилгээ, өргөтгөх шинэчлэлийн ажил хийсэн бол баталгаа гаргаж өгөх;

ДӨРӨВ. ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨЛБӨР ТООЦОО

4.1 Хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний зарцуулалтын тооцоог эрх бүхий байгууллагын баталгаажуулсан, хангагчийн ажилтны битүүмжилсэн тооцооны хэмжих хэрэгсэл, тоолуурын заалтыг баримтлан хийнэ.
4.2 Тооцооны хэмжих хэрэгслийн битүүмжлэл, лац, хэвийн ажиллагаа алдагдсан тохиолдолд акт үйлдэн дараах байдлаар нөхөн төлбөр тооцно. Үүнд:
4.2.1 Хэрэглэгчийн буруугаас шалтгаалж тооцооны хэмжих хэрэгслийн битүүмжлэл, хяналтын лац, хэвийн ажиллагаа алдагдсан тохиолдолд тооцоог хийхдээ хэрэглэгчийн суурилагдсан чадлыг ажиллавал зохих цаг (сүүлийн удаа шалгалт хийснээс хойш тухайн зөрчлийг арилгах хүртэлх)-аар үржүүлж тооцно;
4.2.2 Тооцооны хэмжих хэрэгслийн битүүмжлэл, хяналтын лац, хэвийн ажиллагаа нь хэрэглэгчээс шалтгаалаагүй, тохиолдолд хэрэглэгчийн тухайн сарын хэрэглээг “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 7.6 дугаар заалтыг үндэслэн өмнөх 3 сард хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний дунджийг баримталж төлбөрийг тооцно;
4.3 Тоолуур баталгаажуулах, солих үеийн тоолуургүй хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний тооцоог хэрэглэгчийн сүүлийн 3 сарын өдрийн дундаж хэрэглээг тоолуургүй байсан өдрийн тоогоор үржүүлэн тооцно.
4.4 Зөрчилтэй хэрэглэгчдэд нөхөн тооцоо хийх тохиолдолд хангагчийн эрх бүхий ажилтан нөхөн тооцооны акт үйлдэж хэрэглэгчээр гарын үсэг зуруулна.
4.5 Тооцооны хэмжих хэрэгслийг хангагч, хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн эзэмшлийн зааг дээр тавина. Эзэмшлийн зааг дээр тоолуур тавиагүй тохиолдолд эзэмшлийн заагаас хэрэглээг тооцох цэг хүртэлх шугам болон трансформатор (ачааллын болон хоосон явалтын) дахь энергийн алдагдлын тооцоог тухайн шугам тоноглолын эзэмшигч хариуцаж төлнө.

4.6 Хэрэглэгчийн хуурмаг чадлын хэрэглээнээс хамааруулж Эрчим хүчний зохицуулах хорооны Зохицуулагчдын Зөвлөлөөс батлагдсан тогтоолын дагуу чадлын итгэлцүүр ($COS\varphi$) -ээс хамаарсан нэмэлт төлбөр тооцно.

4.7 Төлбөрийн нэхэмжлэлд цахилгаан эрчим хүч хэрэглэсний төлбөр тусгагдахаас гадна сэргээгдэх эрчим хүчийг дэмжих төлбөр, чадлын төлбөр, суурь хураамж, шугам, трансформаторын алдагдал, чадлын итгэлцүүр ($COS\varphi$)-ээс хамааруулж тооцсон төлбөр, нөхөн тооцооны төлбөр, хугацаа хэтрүүлсний алданги, дараа төлбөрт үйлчилгээ үзүүлсэн бол үйлчилгээний төлбөр хураамж, НӨАТ, телевизийн хураамж, мэдээлэл хүргэлтийн төлбөр, бусад нэмэлт төлбөрүүд тусгагдсан байна.

4.8 Хэрэглэгч цахилгаан эрчим хүчний төлбөрөө урьдчилан төлж болно.

4.9 Хэрэглэгч нь хангагчийн төлбөрийн нэхэмжлэл банканд хүргэгдсэнээс хойш гэрээнд заасан хугацаанд нэхэмжилсэн төлбөрийг төлөх бөгөөд энэ хугацаанд төлбөрөө төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутам 0.5%-иар алданги төлнө.

4.10 Байр, орон сууц, хашаа, газрыг өмчлөгч, эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь бусдад худалдах, бэлэглэх, өвлүүлэх, нүүн шилжих, түрээслүүлэхдээ цахилгаан эрчим хүч хэрэглэсэн тооцоогоо хийж дуусган, энэ тухай тодорхойлолтыг хангагчаас авсан байна. Энэ тодорхойлолтыг тухайн байр, орон сууц, хашаа, газрыг шинээр өмчлөгч, эзэмшигч, түрээслэгч, өвлөн авагч нь тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас шаардаж авна. Хэрэв уг тодорхойлолтыг аваагүй тохиолдолд шинээр өмчлөгч, эзэмшигч цахилгаан эрчим хүчний өр төлбөрийг хариуцна.

4.11 Хангагчтай гэрээ байгуулсан үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч, түрээслэгч нас барсан, гадаад, дотоодод 3 сар ба түүнээс дээш удаан хугацаагаар нүүн шилжихдээ хангагчид мэдэгдээгүй, үл хөдлөх хөрөнгийг түрээслэгч, түр оршин суугч нь цахилгаан эрчим хүч хэрэглэсэн төлбөрөө барагдуулалгүй нүүн шилжсэн тохиолдлуудад энэхүү гэрээний 1.1, 1.2-д заасны дагуу хамтран хариуцагч төлбөр, тооцооны зөрчил болон гэрээтэй холбоотой аливаа асуудлыг хариуцан барагдуулна.

4.12 Хэрэглэгч өөрийн тоолуур хэмжих хэрэгсэлд хангагчийн ажилтныг нэвтрүүлээгүй, заалт авах нөхцөлөөр хангаагүй бол хангагчийн ажилтан тэмдэглэл хийж, тухайн сарын хэрэглээг сүүлийн 3 сарын хэрэглээний дунджаар тооцох ба 2 сар дараалан нэвтрүүлээгүй тохиолдолд хангагч талаас цахилгаан эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлнэ.

4.13 Хэрэглэгч техникийн үйлчилгээ авах бол тухайн үйлчилгээний төлбөр хураамжийг урьдчилан төлсөн байх шаардлагатай. Хэрэв хэрэглэгч техникийн үйлчилгээ хүсэх үедээ өмнөх 6 сарын турш цахилгаан эрчим хүчний төлбөр тооцоогоо хугацаанд нь хийсэн, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчөөгүй бол тухайн үйлчилгээний төлбөр хураамжийг дараа төлөх нөхцөлтэйгээр буюу дараа сарын цахилгааны төлбөрийн хураамж дээр нэмж төлүүлэхээр тохирч болно.

4.14 Хэрэглэгч нь цахилгаан эрчим хүчний хэмжээг ±2 хувиас хэтрүүлсэн эсхүл бууруулсан тохиолдолд “Импортын цахилгаан эрчим хүчний графикийн хазайлт тооцох журам”-ын дагуу хангагчийн тавьсан актыг үндэслэн хэтэрсэн хувь тутамд ногдох хазайлтын төлбөрийг төлнө.

ТАВ. ҮНЭ ТАРИФ

5.1 Цахилгаан зарцуулалтын төлбөр тооцоог ЭХЗХ-ны Зохицуулагчдын Зөвлөлөөс батлагдсан хэрэглэгчдэд борлуулах цахилгааны үнэ тарифаар тооцно.

5.2 Төлбөрт үйлчилгээний тооцоог “Биндэгноров ХХК”-ийн Ерөнхий захирлын тушаалаар батлагдсан үнэ тарифыг үндэслэн тооцно.

5.3 Цахилгааны угсралт ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу гэрээний үндсэн дээр хийнэ.

ЗУРГАА. ТООЦООНЫ ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

6.1 Тооцооны тоолуур хэмжих хэрэгслийн өмчлөл нь энэхүү гэрээний нэгдүгээр хавсралтад заасны дагуу тодорхойлогдоно.

6.2 Тооцооны хэмжих хэрэгслийг баталгаажуулах, засварлах, солихтой холбоотой гарах зардлыг өмчийн эзэн хариуцна.

6.3 Хангагчийн эзэмшлийн дэд станц, нэгдсэн щитэнд байрлуулсан тооцооны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангагч хариуцна.

6.4 Хэрэглэгчийн өмчлөлийн үл хөдлөх хөрөнгөд суурилуулсан тооцооны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хэрэглэгч хариуцна.

6.5 Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын эзэмшлийн үл хөдлөх хөрөнгөнд суурилуулсан хэрэглэгчийн тооцооны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хэрэглэгч хариуцна.

6.6 Хангагчийн эзэмшлийн дэд станц, нэгдсэн щитэнд байрласан тоолуур хэмжих хэрэгслийн битүүмжлэл алдагдсан, дутуу тоолсон, эвдэрсэн гацсан алдагдсан бол энэхүү гэрээний 4.2-д заасныг баримтлан дутуу тооцогдсон эрчим хүчийг нөхөж тооцно.

6.7 Хэрэглэгчийн тооцооны хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулах явцад тооцооны хэмжих хэрэгслийг оролдсон, гэмтээсэн шинж тэмдгүүдийг илрүүлсэн бөгөөд үүнд хэрэглэгчийн үйлдэл гарцаагүй нөлөөлсөн гэдгийг тогтоосон бол энэ тухай хэрэглэгчид мэдэгдэж хангагчийн эрх бүхий ажилтан акт үйлдэн, тооцооны хэмжих хэрэгсэл гэмтэлтэй байсан хугацаанд ногдох дутуу тооцсон цахилгаан эрчим хүчний хэрэглээг нөхөн тооцож нэхэмжилнэ.

6.8 Баталгаажуулах хугацаанаас өмнө хэрэглэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа алдагдаж баталгаажуулах шаардлагатай болсон эсвэл хэрэглэгчийн хүсэлтээр тооцооны хэмжих хэрэгслийн ажиллагааг шалгаж баталгаажуулах тохиолдолд хэрэглэгч үйлчилгээний хураамжийг урьдчилан төлөх үүрэг хүлээнэ.

6.9 Хэрэглэгчийн баталгаажуулахаар авчирсан тоолуур нь хангагчийн мэдээллийн санд бүртгэлтэй бөгөөд уг тоолуур хулгайд алдагдсан нь тогтоогдвол зохих хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ. Энэ тохиолдолд хэрэглэгчид учирсан хохирлыг хангагч хариуцахгүй.

6.10 Тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагааг санаатайгаар алдагдуулж хангагчийн шаардлагыг удаа дараа биелүүлээгүй хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг цуцлах хүртэлх арга хэмжээ авах ба шүүхийн байгууллагад шилжүүлнэ.

6.11 Хэрэглэгч нь тоолуурын щит рүү очих орц, гарцыг чөлөөтэй байлгана.

ДОЛОО. ТАЛУУДЫН ХАРИЛЦАН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

7.1 Цахилгаан эрчим хүчний тасалдал, чанарын үзүүлэлтийн хэлбэлзлээс болж хангагчтай гэрээтэй хэрэглэгчид хохирол учирсан тохиолдолд 24 цагийн дотор хэрэглэгч нь хангагчид мэдэгдэж хамтарсан акт үйлдэн гаргасан шийдвэрийг үндэслэн хохирлыг буруутай тал төлнө.

7.2 Цахилгаан эрчим хүчний гэмтэл, тасалдлаас учирсан хохирлыг дор дурдсан тохиолдолд хангагч хариуцахгүй. Үүнд:

7.2.1 Байгалийн гамшиг, гэнэтийн аюул (аянга, салхи, шуурга, мөстлөг, үер, гал түймэр гэх мэт) тохиолдсон;

7.2.2 Хангагчтай тохиролцсон горимыг хэрэглэгч мөрдөөгүйгээс хэрэглэгчийн цахилгаан хангамж тасалдсан;

7.2.3 “Эрчим хүчний тухай хууль”-ийн 29.1.2, 32.1, 32.2, 32.3-т заасны дагуу хэрэглэгчийн цахилгаан хангамжийг тасалсан, түдгэлзүүлсэн;

7.2.4 Хэрэглэгчийн цахилгаан дамжуулагч шугамыг гуравдагч этгээд гэмтээж, эрчим хүчээр тасалдуулсан;

7.2.5 Гэрээний 2.2-ын заалтыг зөрчсөнөөс болон хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан тасралт, саатал, гэмтэл гарснаас цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлсэн;

7.2.6 Цахилгаан эрчим хүчний бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанаас шалтгаалсан аваар, осол болон саатал гарсан; (Нэгдсэн сүлжээнд чадлын дутагдал үүсэж хязгаарлалт хийгдсэн, ОХУ-н системээс хамаарч Төвийн эрчим хүчний систем доголдсон, Сүлжээнд газардлага гарсан, Системийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор томоохон сэлгэн залгалт хийх гэх мэт)

7.2.7 Орон сууцны ерөнхий щит, магистрал шугам, давхар дундын щит гэх мэт гадны эзэмшлийн шугам тоноглолд гарсан гэмтэл болон засвар үйлчилгээ хийгээгүйгээс шалтгаалсан тасралт;

7.2.8 Хангагч талын өмчлөлд холбогдох тогтоол шийдвэрийн дагуу хүлээлгэн өгөөгүй болон хэрэглэгч өөрөө эсвэл гуравдагч этгээд ашиглалт засвар, үйлчилгээг нь хариуцаж байгаа дэд станц, барилгын 0,4 кВ-ын кабель шугам, цахилгаан тоноглолд гэмтэл, саатал гарсан;

7.2.9 Хэрэглэгч нь 7.1-д заасан хугацаанд тасралттай холбоотой өргөдөл, гомдол гаргаагүй тохиолдолд.

7.3 Хэрэглэгч өөрийн буруутай үйлдэл мөн өөрийн өмчлөлийн, эзэмшлийн гэрийн тэжээвэр амьтдыг зохих хамгаалалтгүй байлгасны улмаас хангагчийн ажилтнуудад хохирол учруулсан бол холбогдох хууль, дүрмийн дагуу эмчилгээний зардал болон бусад учруулсан хохирлыг хэрэглэгч хариуцна.

7.4 Зар, мэдээлэл сануулгыг хэрэглэгчийн гэрээнд заасан утасны дугаараар хүргүүлэх бөгөөд холбоо барих утасны дугаар өөрчлөгдсөнийг хангагч талд албан ёсоор мэдэгдээгүй болон мессеж хүргэх үед гар утасны оператор компаниудын үйл ажиллагаа саатсан, хэрэглэгчийн утас сүлжээгүй, унтарсан байснаас мэдэгдэл мессеж очоогүйгээс гарах хохирлыг хангагч тал хариуцахгүй.

7.5 Хэрэглэгч нь ямар нэгэн төлбөрт үйлчилгээг хангагчтай зөвшилцөж албан ёсны үйлчилгээ авалгүй хангагчийн төлөөлөгч гэх хувь хүнтэй хэлцэл хийж ажил үйлчилгээ авсан бол үүнээс үүдэн гарах хохирлыг хангагч тал хариуцахгүй.

7.6 Хэрэглэгч нь 2.2.2-д заасны дагуу гэрээнд өөрчлөлт оруулаагүй, гэрээний хугацаа дууссан болон гэрээнд өөрчлөлт оруулахаар хангагч талаас мэдэгдэл өгөхөд ирээгүй нь хэрэглэгч үүрэг хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

7.7 Гэрээний 2.2.1-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүдэн гарах аливаа хохирлыг хангагч хариуцахгүй.

7.8 Хэрэглэгч өөрийн хэрэглээнээс зөвшөөрөлгүй нэмж хэрэглэгч холбох, стандартын шаардлага хангаагүй тоног төхөөрөмж, цахилгааны кабель, утас хэрэглэх зэргээс шалтгаалж хүчдэлийн түвшин багасах, түүнээс үүссэн бусад хохирол болон хангагч талын тоног төхөөрөмж, кабелийг гэмтээсэн бол хохирлыг хэрэглэгч бүрэн хариуцна.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

8.1 Талууд аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Хэрэв харилцан тохиролцон шийдвэрлэж чадахгүй бол асуудлыг дараах байдлаар шийдвэрлүүлнэ.

8.1.1 Хангагч, хэрэглэгч талуудын хооронд гарсан маргаантай асуудал нь Эрчим хүчний тухай хуулийн 35.2-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны бүрэн эрх мэдэлд хамаарах бол тус хороонд гаргаж шийдвэрлүүлнэ; (Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд явуулж буй хангагчийн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд хамаарна. Үүнд: эрчим хүчний үнэ тариф, түүнийг тооцох аргачлал, цахилгаан тоног төхөөрөмжтэй холбоотой гэх мэт)

8.1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч нь Эрчим хүчний тухай хуулийн 35.2-т заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.

8.2 Хэрэглэгч өөрийн хэрэглэсэн эрчим хүчний төлбөрөө гэрээний хугацаандаа төлөөгүйгээс авлага үүсгэсэн, төлөхөөс зайлсхийсэн, хангагч талтай байгуулсан авлага хэсэгчлэн барагдуулах гэрээний үүргээ зөрчсөн бол албадан төлүүлэх зорилгоор харьяа шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

ЕС. ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ, ДҮГНЭХ, ЦУЦЛАХ

9.1 Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журамд өөрчлөлт орсон тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө шинэчлэн байгуулж болно.

9.2 Хангагч, хэрэглэгч талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү өөрчлөлтийг “гэрээний нэмэлт, өөрчлөлт”-д бичиж талууд гарын үсэг зурж баталгаажуулна. (Үйл ажиллагааны чиглэл, техникийн нөхцөл, хэрэглэгчийн ангилал өөрчлөгдөх, холболтын цэг нэмэгдэх гэх мэт)

9.3 Энэхүү гэрээний хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарсан тохиолдолд хангагч нь утас, цахим, бичгийн аль нэг хэлбэрээр хэрэглэгчид мэдэгдэх бөгөөд заасан хугацаанд хэрэглэгч баталгаажуулаагүй нь уг өөрчлөлтийг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.

9.4 Хэрэглэгч гэрээний хугацаа дуусахаас нэг сарын өмнө хангагчтай тооцоо нийлж, гэрээ дүгнэсэн протокол үйлдэнэ.

9.5 Гэрээний хугацаа дуусахаас нэг сарын өмнө талууд гэрээ цуцлах санал гаргаагүй болон хэрэглэгч төлбөрийн зөрчилгүй байвал гэрээг анх заасан хугацаагаар гэрээ дүгнэсэн протоколыг үндэслэн сунгана. Гэрээний 9.4-д заасан үүргээ биелүүлж гэрээний хугацаа сунгасан, дүгнэсэн протоколд хэрэглэгч гарын үсэг зурж баталгаажуулаагүй бол хангагч дангаар гэрээг сунгаж баталгаажуулна. Энэ тохиолдолд гэрээний хугацааг сунгагдсанд тооцож, хүчин төгөлдөр гэрээ гэж үзнэ;

9.6 Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг хуульд зааснаас гадна дараах нөхцөлд хугацаанаас нь өмнө цуцална.

9.6.1 Аль нэг талын санаачилгаар;

9.6.2 Хэрэглэгч гэрээний үүргээ зөрчсөн, хангагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй, эрх бүхий байгууллагын /хууль, шүүхийн, мэргэжлийн хяналт болон бусад/ эцсийн шийдвэрээр цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлж гэрээ цуцлах тухай шийдвэр, тогтоол гарсан;

9.6.3 Тоолуур хэмжих хэрэгслийг хангагч байгууллагад мэдэгдэлгүй дур мэдэн солих, холболтыг өөрчлөх, битүүмжлэлийн 3-р лацыг оролдох, тасалсан үйлдлийг 3-аас дээш удаа үйлдсэн нь нотлогдвол нэг талын санаачилгаар гэрээ дуусгавар болгоно.

9.7 Өмчийн эзэн, эзэмшигч солигдсон тохиолдолд өмнөх гэрээг цуцалж, шинээр гэрээ байгуулна.

9.8 Өр төлбөрийн үлдэгдэлтэй хэрэглэгчийн гэрээг цуцлахгүй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН :

ХАНГАГЧ:

Биндэгноров ХХК-ийн ХТҮАХ Захирал

.....

_____ (гарын үсэг)

Ажилтан .....

_____ (гарын үсэг)

Утас: 75050507

Хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Ривер стоун хотхон, 26А байр 101 тоот

ХЭРЭГЛЭГЧ:

…….....….-д ажилтай

_____ (гарын үсэг)

Утас: .....

Хамтран хариуцагч

.....

_____ (гарын үсэг)

Утас .....

Түрээслэгч

.....

_____ (гарын үсэг)

Утас .....

Хаяг:.....

.....

Цахилгаан эрчим хүчээр хангах
гэрээний НЭГДҮГЭЭР хавсралт

ХАНГАГЧ, ХЭРЭГЛЭГЧ ХООРОНДЫН ЭЗЭМШЛИЙН ЗААГ

1. Талуудын эзэмшлийн заагийг ..... хувилбараар тогтоов.
Техникийн нөхцөлийн дугаар ..... огноо .....

Хэрэглэгчийн хүчний трансформаторын суурилагдсан чадал _____кВА
Хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн суурилагдсан чадал _____кВт
Хүчдэлийн түвшин _____кВ
Тоолуурын өмчлөл _____


1

РП-ХТП

(Хангагчийн эзэмшлийн РП-ээр дамжин тэжээгдэж буй хэрэглэгчийн ХТП-г зааглах схем)

Хангагч
РП-ны нэр:.....
РП-ны дугаар:.....

Хэрэглэгч
ХТП-ны нэр:.....
ХТП-ны дугаар:.....



ЦДКШ-ын : Марк..... Урт .....


2

РП-КТП(Н,В)

(Хангагчийн эзэмшлийн РП-ээр дамжин тэжээгдэж буй хэрэглэгчийн КТП(Н,В)-г зааглах схем)

Хангагч
РП-ны нэр:.....
РП-ны дугаар:.....

Хэрэглэгч
КТП(Н,В)-ны нэр:.....
КТП(Н,В)ны дугаар:.....



ЦДКШ-ын : Марк..... Урт .....


3

ХТП-ХТП

(Хангагчийн эзэмшлийн ХТП-ээр дамжин тэжээгдэж буй хэрэглэгчийн ХТП-г зааглах схем)

Хангагч
ХТП-ны нэр:.....
ХТП-ны дугаар:.....

Хэрэглэгч
ХТП-ны нэр:.....
ХТП-ны дугаар:.....



ЦДКШ-ын : Марк..... Урт .....


4

ХТП-КТП(Н,В)

(Хангагчийн эзэмшлийн ХТП-ээр дамжин тэжээгдэж буй хэрэглэгчийн КТП(Н,В)-г зааглах схем)

Хангагч
ХТП-ны нэр:.....
ХТП-ны дугаар:.....

Хэрэглэгч
КТП(Н,В)-ны нэр:.....
КТП(Н,В)ны дугаар:.....



ЦДКШ-ын : Марк..... Урт .....

5


ХТП-ХТП-ХТП

(Хангагчийн эзэмшлийн ХТП-ээр дамжин тэжээгдэж буй хэрэглэгчийн ХТП-г зааглах схем)

Хангагч
ХТП-ны нэр:.....
ХТП-ны дугаар:.....

Хэрэглэгч
ХТП-ны нэр:.....
ХТП-ны дугаар:.....

Хангагч
ХТП-ны нэр:.....
ХТП-ны дугаар:.....




ЦДКШ-ын : Марк..... Урт .....

6 **ХТП-ЩИТ**

(Хангагчийн эзэмшлийн дэд өртөөний 0,4 кВ-ын хувиарлах байгууламжаар дамжин тэжээгдэж буй хэрэглэгчийн 0,4 кВ-ын щитийг зааглах схем)

Хангангч
ХТП-ны нэр:.....
ХТП-ны дугаар:.....
0,4 кВ-ын ХБ

Хэрэглэгч
0.4 кВ-ын щит
ЕС



ЦДКШ-ын : Марк..... Урт .....


7 **Щит-Щит**

(Хангагчийн эзэмшлийн 0,4 кВ-ын щитнээс хэрэглэгчийн 0,4 кВ-ын щитийг зааглах схем)

……..
0.4 кВ-ын щит
……. байр ЕС/ХС-.....

……
0.4 кВ-ын щит
……. байр АВР-.....

Хэрэглэгч
0.4 кВ-ын щит
ЕС-.....



ЦДКШ-ын : Марк..... Урт .....

8 Нэмэлт заагийн схем

Эзэмшлийн зааг бичиглэлээр:

_____

_____

_____

ХАНГАГЧ:

Биндэгноров ХХК _____
Ахлах инженер_____

….....(Гарын үсэг)

ХЭРЭГЛЭГЧ:

_____-д ажилтай
_____

..... (Гарын үсэг)

Цахилгаан эрчим хүчээр хангах
гэрээний ХОЁРДУГААР хавсралт

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТООЦОО, ТӨЛБӨР ХИЙХ ХУГАЦАА

1. Цахилгаан эрчим хүчний тооцоо, төлбөр хийх хугацаа

   - Үйл ажиллагааны чиглэл _____
   - Ангилал _____
   - Дэд ангилал _____
   - Борлуулалтын цикл _____
   - Үнэ тарифын ангилал _____
   - Хэрэглэгчийн зэрэглэл _____
   - Трансформаторын хоосон явалт тооцох эсэх _____

2. Тоолуур хэмжих хэрэгсэл _____ өмчлөлд байна.

Д/д	Агуулга	R2-р цикл	R3-р цикл	R4-р цикл	R5-р цикл
1	Сар бүрийн тоолуурын заалт авах өдөр	5-10	11-15	16-20	21-25
2	Төлбөрийн нэхэмжлэлийг банкинд хүргэсэн байх өдөр	Сар бүрийн 11-с хойш	Сар бүрийн 16-с хойш	Сар бүрийн 21-с хойш	Сар бүрийн 26-с хойш
3	Төлбөр төлөх боломжит хоног	11-15	16-20	21-25	26-30
4	Алданги тооцож эхлэх өдөр	Сар бүрийн 16-наас	Сар бүрийн 21-нээс	Сар бүрийн 26-наас	Сар бүрийн 1-нээс
5	Эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлж эхлэх өдөр	Сар бүрийн 16-наас хойш	Сар бүрийн 21-нээс хойш	Сар бүрийн 26-наас хойш	Сар бүрийн 1-нээс хойш

3. Хэрэглэгчийн төлбөр төлөх банк:
   3.1 Хаан банк: **MN 06000500 5131130536** дансны нэр “Биндэгноров”
   3.2 Төрийн банк: **MN 340034 341801640619** дансны нэр “Биндэгноров”
   3.3 Худалдаа хөгжлийн банк: **MN 110004000 415119118** “Биндэгноров”
4. Хэрэглэгчийн мэдээлэл авах хаяг, хэрэглэгчийн утасны дугаар өөрчлөгдөх бүрт хангагчид мэдэгдэж гэрээнд тусгуулах ба мэдэгдээгүй улмаас үүдэн гарах хохирлыг хангагч хариуцахгүй.

   4.1 **Хэрэглэгчийн төлбөрийн мэдээлэл мессежээр авах утасны дугаар**:
   ……..……..

(*Сар бүр таны хэрэглэсэн цахилгааны төлбөр, төлбөр төлөх хугацаа, хэрэглээг түдгэлзүүлэх тухай мэдээллүүдийг илгээнэ.*
Billcenter гар утасны АПП ашиглаж төлбөрийн мэдээлэл болон Е-бариmтыг авч болно.)

   4.2 **Хэрэглэгчийн и-мэйл хаяг:** .....

(Хэрэглэгч интернэт банк, мобайл банк болон АТМ-ээр цахилгааны төлбөрөө төлсөн тохиолдолд НӨАТ-ийн бариmтыг илгээнэ.)

   4.3 **Хэрэглэгчийн фейсбүүк хаяг:** ……

(*Хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх, хэрэглэгчийн санал, хүсэлтийг хүлээн авч, хариу өгнө.*)

Цахилгаан эрчим хүчээр хангах
гэрээний ГУРАВДУГААР хавсралт

ХЭРЭГЛЭГЧИЙН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАХИАЛГА:

…….он

Хугацаа /сар/	Захиалга	Гүйцэтгэл	Зөрүү	Хугацаа /сар/	Захиалга	Гүйцэтгэл	Зөрүү
	/кВт.ц/	/кВт.ц/	%		/кВт.ц/	/кВт.ц/	%
1 сар				7 сар			
2 сар				8 сар			
3 сар				9 сар			
Улирлын дүн				Улирлын дүн			
4 сар				10 сар			
5 сар				11 сар			
6 сар				12 сар			
Улирлын дүн				Улирлын дүн			
Эхний хагас жилийн дүн:				Сүүлийн хагас жилийн дүн:			

…….он

Хугацаа /сар/	Захиалга	Гүйцэтгэл	Зөрүү	Хугацаа /сар/	Захиалга	Гүйцэтгэл	Зөрүү
	/кВт.ц/	/кВт.ц/	%		/кВт.ц/	/кВт.ц/	%
1 сар				7 сар			
2 сар				8 сар			
3 сар				9 сар			
Улирлын дүн				Улирлын дүн			
4 сар				10 сар			
5 сар				11 сар			
6 сар				12 сар			
Улирлын дүн				Улирлын дүн			
Эхний хагас жилийн дүн:				Сүүлийн хагас жилийн дүн:			

…….он

Хугацаа /сар/	Захиалга	Гүйцэтгэл	Зөрүү	Хугацаа /сар/	Захиалга	Гүйцэтгэл	Зөрүү
	/кВт.ц/	/кВт.ц/	%		/кВт.ц/	/кВт.ц/	%
1 сар				7 сар			
2 сар				8 сар			
3 сар				9 сар			
Улирлын дүн				Улирлын дүн			
4 сар				10 сар			
5 сар				11 сар			
6 сар				12 сар			
Улирлын дүн				Улирлын дүн			
Эхний хагас жилийн дүн:				Сүүлийн хагас жилийн дүн:			

ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

..... оны ..... дугаар сарын .....

.....

.....

.....

.....

.....

ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН:

ХАНГАГЧ:
БИНДЭГНОРОВ ХХК-ИЙН
ХТҮАХ ЗАХИРАЛ _____

.....(нэр)
(_____)
(Гарын үсэг)

ХЭРЭГЛЭГЧ:
_____
_____ АЖИЛТАЙ

..... (нэр)
(_____)
(Гарын үсэг)

БИНДЭГНОРОВ ХХК-ИЙН
АЖИЛТАН.....

.....(нэр)
(_____)
(Гарын үсэг)

ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

..... оны ..... дугаар сарын .....

.....

.....

.....

.....

.....

ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН:

ХАНГАГЧ:
БИНДЭГНОРОВ ХХК-ИЙН
ХТҮАХ ЗАХИРАЛ _____

.....(нэр)
(_____)
(Гарын үсэг)

ХЭРЭГЛЭГЧ:
_____
_____ АЖИЛТАЙ

..... (нэр)
(_____)
(Гарын үсэг)

БИНДЭГНОРОВ ХХК-ИЙН
АЖИЛТАН.....

.....(нэр)
(_____)
(Гарын үсэг)

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ПРОТОКОЛ

.....он .....сар .....өдөр № Улаанбаатар хот

Гэрээний биелэлтийн байдалд өгөх дүгнэлт:

.....
.....
.....
.....

Шийдвэрлэсэн нь:

.....
.....
.....

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

ХАНГАГЧ:
БИНДЭГНОРОВ ХХК-ИЙН
ХТҮАХ ЗАХИРАЛ _____

.....(нэр)
(_____)
(Гарын үсэг)

ХЭРЭГЛЭГЧ:
_____
_____ АЖИЛТАЙ

..... (нэр)
(_____)
(Гарын үсэг)

БИНДЭГНОРОВ ХХК-ИЙН
АЖИЛТАН.....
.....(нэр)
(_____)
(Гарын үсэг)

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ПРОТОКОЛ

.....он .....сар .....өдөр № Улаанбаатар хот

Гэрээний биелэлтийн байдалд өгөх дүгнэлт:

.....
.....
.....
.....

Шийдвэрлэсэн нь:

.....
.....
.....

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

ХАНГАГЧ:
БИНДЭГНОРОВ ХХК-ИЙН
ХТҮАХ ЗАХИРАЛ _____

.....(нэр)
(_____)
/Гарын үсэг/

ХЭРЭГЛЭГЧ:
_____
_____ АЖИЛТАЙ

..... (нэр)
(_____)
гарын үсэг

БИНДЭГНОРОВ ХХК-ИЙН
АЖИЛТАН.....
.....(нэр)
(_____)
/Гарын үсэг/

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ПРОТОКОЛ

.....он .....сар .....өдөр № Улаанбаатар хот

Гэрээний биелэлтийн байдалд өгөх дүгнэлт:

.....
.....
.....
.....

Шийдвэрлэсэн нь:

.....
.....
.....

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

ХАНГАГЧ:
БИНДЭГНОРОВ ХХК-ИЙН
ХТҮАХ ЗАХИРАЛ _____

.....(нэр)
(_____)
(Гарын үсэг)

ХЭРЭГЛЭГЧ:
_____
_____ АЖИЛТАЙ

..... (нэр)
(_____)
(Гарын үсэг)

БИНДЭГНОРОВ ХХК-ИЙН
АЖИЛТАН.....

.....(нэр)
(_____)
(Гарын үсэг)

ТЭМДЭГЛЭЛ

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....